



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 4/666.

Ховд

Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/05 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд хотын шинэ хороолол байгуулах 245 га газраас 1 га газрыг Ховд “Цахилгаан түгээх сүлжээ” ХХК /2684853/-д ажилчдын орон сууц, албан хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуй нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-д даалгасугай.

3.Аймгийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хангаж хяналт тавьж ажиллахыг аймгийн ерөнхий архитектор, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын хэлтсийн дарга /З.Өмиртай/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Зах А/666/Сн
02 03296